



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ АРХИВ



2016 он



Геологийн мэдээллийн төв архивын орон тоо, ажлын зохион байгуулалт

-2015 оны Уул уурхайн яамны сайдын 2 дугаар сарын 27-ний өдрийн 35 дугаар тушаал, Ашигт малтмалын газрын даргын 2015 оны б/74 дугаар тушаалаар Геологийн албаны нэгжинд 8 орон тоотой ажилласан. Үүнд:

- ГМТ-ийн архивын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн-1
- Сан хөмрөг, үйлчилгээ хариуцсан геологич-2
- Анхдагч, нууц, каталоги хариуцсан геологич-1
- Чулуун сан хариусан геологич-1
- Хувийн гаралтай тайлан, мэдээлэл хариуцсан геологич-1
- Сэлбэн засагч-1
- Олшруулагч-1

ТӨРИЙН АРХИВЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Уншлагын танхимаар: Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнд хууль, журамд заасны дагуу геологийн судалгааны ажлын тайлан, анхдагч, агаарын зураг, мэргэжлийн ном болон бусад мэдээллээр үйлчилгээ үзүүлэх ажил 2016 оны эхний хагас жилд 2046 хүнд, 3889 тайлан, 7778 номоор үйлчилгээ үзүүлж, А4-19837 хуудас, А3- 6300 зураг хувилж, 174 зургийг скайнердаж, 1394 жилийн ажлын төлөвлөгөө архивлаж, Улсын төсөвт нийт 59.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажиллаа.


АМГ-ын дотоод ажлын хэрэгцээнд: 14993 хуудас, 996 зураг

Хууль хяналтын байгууллагад: 5009 хуудас хувилж, лавлагаа гаргасан байна.


-Төрийн болон төрийн бус байгууллага, ААН, хувь хүнээс ирүүлсэн 90 албан хүсэлт хүлээн авч, лавлагаа гаргаж, албан бичгийг хугацаанд нь хаалгаж, бүртгүүлсэн байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨСӨЛТ


2016 оны 1-6 сард



ШИНЭЭР БАРИМТ ХҮЛЭЭН АВЧ, САН ХӨМРӨГ НӨХӨН БҮРДҮҮЛЭХ АЖИЛ



ТӨРИЙН САНД ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭЛТ



Төрийн архивын цахим сан бүрдүүлэлтийн талаар хийгдсэн ажил

Монгол Улсын Засгийн газрын 64-р тогтоолоор “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд **“Геологийн архивын бүртгэлийг цахимжуулах, радио давтамжит төхөөрөмжид шилжүүлэх”** төслийг боловсруулж, сонгон шалгаруулалтын зарчмаар явуулж, ARCU4 программ хангамжийг нэвтрүүлж эхэлсэн. Ажлын зорилго: Bar Cod-жуулах


The image illustrates the implementation of the ARCU4 program for digitizing geological archives. It features a photograph of a physical archive room with bookshelves and a barcode scanner, alongside two screenshots of the ARCU4 web application interface.

The top screenshot shows the ARCU4 web application interface. The main content area displays a list of archive items with columns for 'Хайлт' (Search) and 'Хяналт' (Status). The list includes items such as '1. В.Н.Борзина', '2. В.Н.Борзина, С.В.Егоров', '3. В.Н.Борзина', '4. А.Я.Степанов', '5. Е.Э.Рауунов', '6. Е.Э.Рауунов', '7. В.К.Чайковский', '8. В.К.Чайковский', and '9. В.К.Чайковский'. The right sidebar shows a detailed view of a selected item, including its title 'Дорожная альбомный журнал', author 'В.Н.Борзина, С.В.Егоров, Г.С.Левченко, М.Т.Линин, С.В.Егоров, В.Я.Лин', and other metadata.

The bottom screenshot shows a grid of barcode labels for the archive items. Each label includes a barcode and the text 'ГЕОЛОГИЙН ТӨВ АРХИВ' (Geological Archive) along with specific item details like 'Негц хяналт: 8994, Хавтас: 1, Дэлгэр: 1'.


Архивын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хэрэгжилт

Улсын хэмжээнд 1:50 000-ны зураглал хийгдсэн талбайн хэмжээ, нутаг дэвсгэрт бүрхэгдсэн хувийг тодорхой болгох зорилгоор нийтдээ 480 тайлангаас шүүлт хийж, талбайн байршлыг шалгаж, нэмэлт баяжуулалтыг хийж, бичвэр хэсгийг боловсруулан 2016 оны 4-р сарын 7-ний өдөр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан.



Хувийн хөрөнгөөр хийгдсэн судалгааны ажлын мэдээлэлээр цахим сан үүсгэх, зураг боловсруулах

Геологийн мэдээллийн төв архивт шинээр бүртгэгдэж байгаа хувийн гаралтай баримтуудаас мэдээлэл бэлтгэж, цахим сан бүрдүүлэх ажлын хүрээнд 2016 оны эхний хагас жилд 120 ордын мэдээлэл, 10 ордын ТЭЗҮ-ийн мэдээлэл шинээр боловсруулж, цахим санд нэмэлт баяжуулалт хийлээ.



Хээрийн судалгааны анхдагч баримтанд нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийгдсэн байдал.

2016 оны эхний хагас жилд 120 анхдагч баримтанд дахин боловсруулалт хийж, тоо бүртгэлийг Access программд оруулсан.



Баримтын тоо бүртгэл, каталогижуулалт, сэлбэн засаж, сэргээн шинэчлэх ажил

-Архивын нөөц, ашиглалтын, нууцын, хувийн хөрөнгө, ТЭЗҮ-ийн зэрэг 7 хөмрөгийн данс бүртгэл, өөрчлөлт хөдөлгөөний мэдээг гаргаж, архивын 7 өрөөний 500 ш шүүгээний 2400 тавиурт заагч шинээр хийлээ.

-Геологийн салбарт ажиллаж байгаа, архивт хөмрөг үүсгэгч 325 геологичид, 22 байгууллагын бүтээлийн жагсаалтыг боловсруулан гаргасан.

-Төрийн нууцтай холбоотой ажлуудад оролцож, ажилтнуудын дардас, тэмдэгтүүдийн бүртгэлийг шинэчлэн бүртгэлд авлаа.

-1:1000 000-16 лист, 1:500 000-48 лист, 1:200 000-312 лист, 1:100 000-ны масштабын 543 листийн байр зүйн зургийн бүртгэлийг шинэчилэн хийлээ.

-Хувийн хөрөнгөөр хийгдсэн 7715-7868 хүртэлх дугаартай 82 ш тайлан, 10 ш ТЭЗҮ-ийн цахим мэдээлэл боловсруулж, цахим санд баяжуулалт хийж, 567 каталоги шинээр бичиж, 28 тайланд ашиглалтын хөмрөг үүсгэж, 109 хавтас шинээр хийж, 16 ном хавтаслаж, 104 зурагт сэлбэн засалтын ажил хийгдлээ.

-УУЯ-ны сайдын ОХУ-ын Геологийн архиваас тайлан татаж авах ажлын хэсэгт ажиллаж, 800 тайлангийн каталогид шүүлт хийж, тус архивт ирээгүй тайлангуудын жагсаалт гаргаж, УУЯ-нд хүргүүлсэн.

-Геологи-хайгуул-2016 чуулга уулзалтанд зориулан 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын судалгааны зураг (картограмм), 1:200000-ны масштабтай геологийн зураглалын ажил хийгдсэн талбайн байршлын зураг (картограмм), Монгол улсын 1:200000-ны масштабтай геологийн зургийн картограмм (Улсын геологийн зураг-200), УГЗ-200-д зориулан серийн легендэд хуваасан зургийг тус тус тайлбар жагсаалтыг хамт хэвлэн гаргалаа.

ЧУЛУУН ДЭЭЖИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ

2016 оны эхний хагас жилд Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн Эмээлцэгийн нуруу, Тогоо хайрхан, Баяндалай төслийн тайлангийн 42 чулуун дээж, 30 аншлиф, 110 шлиф, хувийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн 6 ордын эталон дээжийг тус тус бүртгэлийн дагуу хүлээн авч, санд бүрдүүлэлт хийсэн.



Баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажил

Архивын баримтыг зориулалтын байранд зохих горимын дагуу хадгалах зорилгоор хадгалалтын горим алдагдсан зарим баримтуудыг өөр өрөөнд шилжүүлэн байршуулах, архивын коридорт болон уншлагын танхимд засварын ажил хийлгэх санал гаргаж, Байр ашиглалтын албатай хамтран зохион байгуулж, архивын тохижилтонд 2,2 сая/төг, нэг цонхны үйлчилгээний тохижилтонд 3,5 сая/төг тус тус зарцуулсан.



Баримтын тооллогын мөрөөр авсан арга хэмжээ.

Нэгдсэн тооллогын актыг үндэслэн 2016 оны 05 сарын 18-ны өдөр Архивын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Р. Энхсайхан, нууцын асуудал хариуцсан геологич Ц. Цэрэндулам, сэлбэн засагч Л. Цэцэгээ, Б. Отгонтөгс нар баримтын ашиглалтын явцад бүртгэгдээгүй орхигдсон тайлангуудыг дахин тоолох, алгасаж дугаарлагдсан хавсралт зурагт үзлэг шалгалт хийх, сэлбэн засч, сэргээн шинэтгэх боломжгүй баримтыг тогтоох, улмаар устгах жагсаалтад оруулах, хувийн гаралтай баримтын зарим зургийг эзэмшигч байгууллага хүлээлгэн өгсөн эсэхийг данс бүртгэлээс нягтлан шалгах зэрэг асуудлуудыг тодорхой болгох зорилгоор хяналтын хэсэгчилсэн тооллого явууллаа.

Мөн агаарын зургийн тооллогын бүртгэлийг ашиглан архивт хадгалагдаж байгаа 651651 агаарын зургийн бүртгэлийг ашиглалтанд зориулан картограмм боловсруулан гаргаж, архивын үйлчилгээний өрөөнд рамлаж байршууллаа.

ТӨРИЙН АРХИВЫН УЛСЫН ҮЗЛЭГТ БЭЛТГЭХ АЖИЛ

Хууль зүйн сайдын 2016 оны 02 сарын 17-ны өдрийн а/43 тоот тушаал, Архивын ерөнхий газрын даргын 2016 оны 04 сарын 19-ны өдрийн а/29 дүгээр тушаалын дагуу Төрийн архивын улсын үзлэг явагдлаа.

Улсын үзлэгийн гишүүдээр АЕГ-ын дэд дарга Улсын ахлах байцаагч Г.Билгүүн, Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга Ч. Оюунчимэг, Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн улсын байцаагч Т. Түвшинтөгс, Мэргэжил арга зүйн удирдлага арга зүйн мэргэжилтэн Т. Сайнжаргал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2016 оны 06 дүгээр сарын 06-ний өдрөөс 06 дүгээр сарын 10-ны өдрүүдэд архивын ажлын зохион байгуулалт, мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдал, баримтын хадгалалт хамгаалалт, тоо бүртгэл, нягтлан шалгалт, баримтын ашиглалт, үйлчилгээ гэсэн 10 бүлэг, 97 аргачлалаар Улсын үзлэг явууллаа.

Үзлэгийн дүн:

1. Архивын ажлын зохион байгуулалт 84 (B)
2. Баримтын хадгалалт хамгаалалт 93 (A)
3. Архивын тоо бүртгэл 95 (A)
4. Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт 93 (A)
5. Нягтлан шалгах ажлын арга зүй, зохион байгуулалт 95(A)
6. Баримтын ашиглалт, үйлчилгээ 94 (A)
7. Мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдал 100 (A)
8. Мэдээлэл лавлагааны сан 98 (A)
9. Мэргэжил арга зүйн зөвлөгөө 95 (A)
10. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи мэргэжлийн хяналт шалгалт 94 (A)

Нийт 94,1% -тайгаар улсын үзлэгт дүгнэгдлээ.